



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/115/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт	17
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Албан шаардлага	19
4.1 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/45

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

005020303

D:\Alban bichig\A4-toot.docx


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>555,713,710.47</u>	<u>406,418,638.00</u>
33	АВЛАГА	316,331,313.47	139,885,200.00
335	Бусад авлага	316,331,313.47	139,885,200.00
3351	Байгууллагаас авах авлага	315,207,923.47	139,885,200.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,123,390.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	353,292.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	353,292.00	00.00
34713	Цалингийн урьдчилгаа	353,292.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	239,029,105.00	255,199,438.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	50,790,800.00
354	Хангамжийн материал	239,029,105.00	202,848,638.00
35410	Бичиг хэргийн материал	1,914,300.00	8,058,500.00
35420	Аж ахуйн материал	233,258,305.00	149,192,838.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,856,500.00	3,040,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,000,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	1,395,000.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	40,162,300.00
35600	Мал амьтад	00.00	1,560,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	00.00	11,334,000.00
36600	Бусад нөөц	00.00	11,334,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,263,742,701.10</u>	<u>7,085,370,768.04</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,263,742,701.10	7,085,370,768.04
391	Газар	493,380.00	493,380.00
392	Биет хөрөнгө	6,684,186,321.20	6,525,564,387.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,524,843,110.57	6,574,893,110.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	(485,081,972.70)	(645,120,135.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	554,754,000.00	569,354,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(252,493,583.31)	(303,516,361.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	261,612,698.79	380,388,084.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(176,318,549.55)	(212,833,694.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	312,142,079.06	348,606,079.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(159,681,461.66)	(195,616,694.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	95,000,000.00	00.00
39217	Ном	9,410,000.00	9,410,000.00
393	Биет бус хөрөнгө	579,062,999.90	559,313,000.08
39301	Програм хангамж	96,300,000.00	96,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(38,550,000.10)	(58,299,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	549,778,000.00	549,778,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(28,465,000.00)	(28,465,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,819,456,411.57</u>	<u>7,491,789,406.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>28,671,596.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,671,596.00	00.00
413	Өглөг	28,671,596.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,344,307.00	00.00
4136	Бусад өглөг	27,327,289.00	00.00

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	25,498,944.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,828,345.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,790,784,815.57</u>	<u>7,491,789,406.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,790,784,815.57	7,491,789,406.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,240,774,740.11	1,240,774,740.11
51101	Өмч: - төрийн	1,240,774,740.11	1,240,774,740.11
512	Хуримтлагдсан үр дүн	5,114,304,306.38	4,815,308,896.85
51210	Өмнөх үеийн үр дүн	5,114,304,306.38	5,114,304,306.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(298,995,409.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,435,705,769.08	1,435,705,769.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,819,456,411.57</u>	<u>7,491,789,406.04</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,299,711,609.00	5,274,943,739.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	177,939,158.00	558,223,834.37
120	Нийтлэг татварын бус орлого	177,939,158.00	558,223,834.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	177,939,158.00	558,223,834.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	101,607,203.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	177,939,158.00	100,392,069.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,121,772,451.00	4,716,719,904.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,603,552,851.00	676,184,604.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,203,552,851.00	676,184,604.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,518,219,600.00	4,040,535,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,518,219,600.00	4,040,535,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,191,742,882.18	5,371,980,815.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,191,742,882.18	5,371,980,815.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,858,547,128.13	5,203,075,346.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,097,833,095.52	1,135,018,742.00
210101	Үндсэн цалин	1,097,833,095.52	1,135,018,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,958,704.05	156,714,696.47
210201	Тэтгэврийн даатгал	127,958,704.05	114,847,829.47
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	11,150,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	8,920,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	2,278,234.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	19,517,933.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	307,002,398.00	315,640,265.00
210301	Гэрэл, цахилгаан	16,966,443.00	20,842,395.00
210302	Түлш, халаалт	257,155,103.00	255,489,323.00

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	11,280,852.00	17,708,547.00
210304	Байрны түрээс	21,600,000.00	21,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	161,393,382.00	186,808,560.00
210401	Бичиг хэрэг	24,646,800.00	29,479,224.00
210402	Тээвэр, шатахуун	85,961,971.00	80,318,077.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,188,356.00	16,100,033.00
210404	Ном, хэвлэл	6,746,100.00	1,393,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	635,000.00	1,320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,215,155.00	23,111,048.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	35,086,278.00
2105	Нормативт зардал	00.00	22,261,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	22,261,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,077,685.00	85,630,203.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	3,755,000.00
210602	Тавилга	00.00	29,670,080.00
210604	Урсгал засвар	27,077,685.00	52,205,123.00
2107	Томилолт, зочны зардал	72,085,200.00	59,072,800.00
210702	Дотоод албан томилолт	44,447,500.00	29,239,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	27,637,700.00	29,833,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,550,092,417.20	626,653,228.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,538,953,900.20	612,599,055.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,415,830.00	10,522,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,512,880.00	928,004.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	253,000.00	176,000.00
210807	Газрын төлбөр	1,456,807.00	1,828,169.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,515,104,246.36	2,615,275,002.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,214,350,431.00	2,253,932,017.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,360,480.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	284,393,335.36	361,342,984.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	333,195,754.05	168,905,468.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,524,261.00	56,176,660.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	124,964,605.00	21,027,084.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,073,856.00	16,983,736.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,485,800.00	18,165,840.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	144,671,493.05	112,728,808.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,503,871.25	112,728,808.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>107,968,726.82</u>	<u>(97,037,076.08)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,500,624.98	201,958,333.45
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	31,500,624.98	201,958,333.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(31,500,624.98)	(201,958,333.45)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>76,468,101.84</u>	<u>(298,995,409.53)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>5,326,610,834.80</u>	<u>4,918,719,176.80</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,288,500.00	201,999,272.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,288,500.00	201,999,272.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,288,500.00	201,999,272.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	101,607,203.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,288,500.00	100,392,069.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,256,322,334.80	4,716,719,904.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,737,515,466.80	676,184,604.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,337,515,466.80	676,184,604.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,518,219,600.00	4,040,535,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,518,219,600.00	4,040,535,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	587,268.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	587,268.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>5,281,160,234.80</u>	<u>4,869,247,176.80</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,281,160,234.80	4,869,247,176.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,949,348,012.75	4,700,341,708.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,070,119,329.75	1,142,729,703.00
210101	Үндсэн цалин	502,896,224.40	824,582,903.40
210102	Нэмэгдэл	155,414,125.83	243,154,799.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,084,177.76	74,991,999.80
210104	Урамшуулал	51,442,069.20	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	300,282,732.56	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,642,600.00	148,747,233.00
210201	Тэтгэврийн даатгал	149,642,600.00	106,928,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	11,150,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	8,920,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	2,230,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	19,517,933.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	307,002,398.00	315,640,265.00
210301	Гэрэл, цахилгаан	16,966,443.00	20,842,395.00
210302	Түлш, халаалт	257,155,103.00	255,489,323.00
210303	Цэвэр, бохир ус	11,280,852.00	17,708,547.00
210304	Байрны түрээс	21,600,000.00	21,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	140,619,256.00	147,474,255.00
210401	Бичиг хэрэг	16,200,000.00	33,474,674.00
210402	Тээвэр, шатахуун	83,458,224.00	77,405,900.00

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,470,847.00	17,394,083.00
210404	Ном, хэвлэл	6,052,000.00	1,076,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	635,000.00	1,320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,803,185.00	16,803,198.00
2105	Нормативт зардал	4,760,000.00	1,389,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,760,000.00	1,389,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,735,000.00	62,055,290.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	996,790.00
210602	Тавилга	6,276,000.00	5,224,100.00
210604	Урсгал засвар	38,459,000.00	55,834,400.00
2107	Томилолт, зочны зардал	74,446,750.00	57,739,300.00
210702	Дотоод албан томилолт	44,447,500.00	29,239,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	29,999,250.00	28,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,724,975,162.00	617,124,677.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,713,836,645.00	603,070,504.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,415,830.00	10,522,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,512,880.00	928,004.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	253,000.00	176,000.00
210807	Газрын төлбөр	1,456,807.00	1,828,169.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,433,047,517.00	2,207,441,985.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,416,334,637.00	2,207,441,985.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,712,880.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	331,812,222.05	168,905,468.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	187,140,729.00	56,176,660.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	587,268.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	124,964,605.00	21,027,084.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,073,856.00	16,983,736.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,515,000.00	18,165,840.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	144,671,493.05	112,728,808.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,503,871.25	112,728,808.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>45,450,600.00</u>	<u>49,472,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	45,450,600.00	49,472,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,450,600.00	49,472,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,450,600.00	49,472,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,450,600.00	49,472,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(45,450,600.00)</u>	<u>(49,472,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,240,774,740.11	1,436,102,471.78	3,693,516,118.84	00.00	6,370,393,330.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	396,702.70	00.00	396,702.70
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,240,774,740.11	1,436,102,471.78	3,693,912,821.54	00.00	6,370,790,033.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	356,566,773.95	00.00	356,566,773.95
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,240,774,740.11	1,435,705,769.08	5,114,304,306.38	00.00	7,790,784,815.57
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,240,774,740.11	1,435,705,769.08	5,114,304,306.38	00.00	7,790,784,815.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,240,774,740.11	1,435,705,769.08	5,114,304,306.38	00.00	7,790,784,815.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(298,995,409.53)	00.00	(298,995,409.53)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,240,774,740.11	1,435,705,769.08	4,815,308,896.85	00.00	7,491,789,406.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,140,535,300.00	4,127,344,781.20	13,190,518.80	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,140,535,300.00	4,127,344,781.20	13,190,518.80	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,083,925,500.00	4,071,168,121.20	12,757,378.80	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,122,057,200.00	1,122,057,199.00	1.00	100.0

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	803,910,400.00	803,910,399.40	0.60	100.0
210102	Нэмэгдэл	243,154,800.00	243,154,799.80	0.20	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,992,000.00	74,991,999.80	0.20	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,530,000.00	148,747,233.00	2,782,767.00	98.2
210201	Тэтгэврийн даатгал	106,928,500.00	106,928,500.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,150,400.00	11,150,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,920,300.00	8,920,300.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,230,100.00	2,230,100.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	22,300,700.00	19,517,933.00	2,782,767.00	87.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,461,400.00	315,640,265.00	2,821,135.00	99.1
210301	Гэрэл, цахилгаан	23,600,000.00	20,842,395.00	2,757,605.00	88.3
210302	Түлш, халаалт	255,551,400.00	255,489,323.00	62,077.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	17,710,000.00	17,708,547.00	1,453.00	100.0
210304	Байрны түрээс	21,600,000.00	21,600,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	147,478,200.00	147,474,255.00	3,945.00	100.0
210401	Бичиг хэрэг	33,475,000.00	33,474,674.00	326.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	77,405,900.00	77,405,900.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,394,100.00	17,394,083.00	17.00	100.0
210404	Ном, хэвлэл	1,080,000.00	1,076,400.00	3,600.00	99.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,320,000.00	1,320,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,803,200.00	16,803,198.00	2.00	100.0
2105	Нормативт зардал	1,389,000.00	1,389,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,389,000.00	1,389,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,663,400.00	71,659,290.00	4,110.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	996,790.00	3,210.00	99.7
210602	Тавилга	10,000,000.00	9,999,100.00	900.00	100.0
210604	Урсгал засвар	60,663,400.00	60,663,400.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	57,739,300.00	57,739,300.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	29,239,300.00	29,239,300.00	-	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	28,500,000.00	28,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,772,500.00	40,836,293.00	2,936,207.00	93.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,782,200.00	26,782,120.00	80.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	10,522,000.00	10,522,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	928,100.00	928,004.00	96.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	176,000.00	176,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	4,764,200.00	1,828,169.00	2,936,031.00	38.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2169834500.00	2165625286.20	4,209,213.80	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,169,834,500.00	2,165,625,286.20	4,209,213.80	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56609800.00	56176660.00	433,140.00	99.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,609,800.00	56,176,660.00	433,140.00	99.2

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,027,200.00	21,027,084.00	116.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,416,100.00	16,983,736.00	432,364.00	97.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,166,500.00	18,165,840.00	660.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,140,535,300.00	4,127,344,781.20	13,190,518.80	99.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,040,535,300.00	4,027,174,712.20	13,360,587.80	99.7
132001	Орон нутгийн төсвөөс	4,040,535,300.00	4,027,174,712.20	13,360,587.80	99.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,000,000.00	100,170,069.00	(170,069.00)	100.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000,000.00	100,170,069.00	(170,069.00)	100.2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	76.00	76.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	11.00	11.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,737,515,466.80	676,184,604.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,737,515,466.80	676,184,604.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,737,515,466.80	676,184,604.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,737,515,466.80	676,184,604.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,737,515,466.80	676,184,604.80
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,737,515,466.80	676,184,604.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,737,515,466.80	676,184,604.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400,000,000.00	676,184,604.80
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг Д.Энхжаргал, 2 дугаар гарын үсгийг 2021.01.01-2021.09.01 хүртэл н.Амарбаясгалан, 2021.09.01-ээс нягтлан бодогч С.Гэрэлмаа нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилго. Бүх нийтийн оролцоонд тулгуурласан ил тод, хариуцлагатай засаглалтай, иргэдээ дээдэлсэн, хөгжилд зорьсон төрийн үйлчилгээний оновчтой бодлого зохицуулалтаар аймгаа хангана.

Зорилт. Тогтвортой, мэргэшсэн, ёс зүйтэй төрийн албыг түшиглэн эдийн засаг, эрчимтэй хөгжлийг тэтгэсэн “Ногоон Баянхонгор”-ыг бий болгоно.

Чиг үүрэг. Аймгийн Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслахаар Тамгын газрын үйл ажиллагааг мэргэжлийн үүднээс удирдан зохион байгуулж, Засаг даргын өөрийн эрхэлсэн асуудлаар эцсийн шатны зөвлөгөө өгөх, дэмжлэгээр ханган

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,154,153.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 51,541.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 36,079.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцож 36,079.1 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцож 37,590.5 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 327,667.0 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	555,713.7	406,418.6	(149,295.1)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	316,331.3	139,885.2	(176,446.1)
Урьдчилгаа	353.3	-	(353.3)
Бараа материал	239,029.1	266,533.4	27,504.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,263,742.7	7,085,370.8	(178,371.9)

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө	8,404,333.3	8,529,222.7	124,889.4
Хуримтлагдсан элэгдэл	(1,140,590.6)	(1,443,851.9)	(303,261.3)
Нийт хөрөнгө	7,819,456.4	7,491,789.4	(327,667.0)
Өр төлбөр	28,671.6	-	(28,671.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,790,784.8	7,491,789.4	(298,995.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,819,456.4	7,491,789.4	(327,667.0)

Өмнөх онд авлагын данс 316,331.3 мянган төгрөг байсан бол тайлант онд 139,885.2 мянган төгрөг болж 176,446.1 мянган төгрөгөөр буурсан байна. Авлагыг харилцагч тус бүрээр харуулбал:

Хүснэт№ 2. Авлагын дэлгэрэнгүй

№	Хаанаас авсан	Он	Хөрөнгийн нэр	Авлагын Мөнгөн дүн	Төлөгдсөн Мөнгөн дүн	Авлагын үлдэгдэл
1	Баянхонгор констракшн	2020	малчдаас худалдан авсан мах эргэн төлөгдөх нөхцөлтэй	40,000.0	-	40,000.0
2	Цэргийн штаб	2020	Давхар шилжсэн мөнгө	746.8	746.8	-
3	БАМБТ төв НҮТББ	2020	Давхар шилжсэн мөнгө	187.5	187.5	-
4	АЙЕТИ ЮНИПИКЭШН ХХК	2020	Принтер үнэ	3,100.0	3,100.0	-
5	Сүндэр констракшн ХХК	2020	Давхар шилжсэн мөнгө	720.0	720.0	-
6	Баялаг байгаль ХХК	2018	Архивын ном	1,500.0	-	1,500.0
7	НДХэлтэс	2020	НДШ	12600,47	12600,47	-
8	Ашид Мөнх Тод ХХК	2020	Бичиг хэрэг	85.0	85.0	-
9	Баян жаргалант хүнс ХХК	2020	Махны үнэ	40,000.0	40,000.0	-
10	М.Дүгэрмаа	2020	Маскны үнэ	19,680.0	19,680.0	-
11	Баян хөх бүрд ХХК	2020	Махны үнэ	40,000.0	40,000.0	-
12	Өндөр буянт хонгор ХХК	2020	Махны үнэ	40,000.0	-	40,000.0
13	Натурал грийн фүүдс ХХК	2020	Махны үнэ	40,000.0	20,000.0	20,000.0
14	Эн Эн Си Си ХХК	2020	Өвс, буудай худалдан авснаас үүссэн	89,176.0	50,790.8	38,385.2
15	Бусад			1,136.0	1,136.0	-
	Дүн		ДҮН	316,331.3	176,446.1	139,885.2

Бараа материалын дансны үлдэгдэл 266,533.4 мянган төгрөг болж 27,504.3 мянган төгрөгөөр өссөн нь бэлэн бүтээгдэхүүн 50,790.8 мянга, бичиг хэргийн материал 6,144.2 мянга, түлш, шатах тослох материал 1,000.0 мянга, барилгын засварын материал 1,395.0 мянга, бусад хангамжийн материал 40,162.3 мянга, мал амьтад 1,560.0 мянган төгрөгөөр өссөн бол аж ахуйн материал 84,065.5 мянга, сэлбэг хэрэгсэл 816.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,529,222.7 мянган төгрөг болж 124,889.4 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын 2021 оны 07, 44 тогтоолуудаар 74,480.0 мянга, аймгийн Засаг даргын 2021 оны А/96, А/196, А/233, А/589, А/ 661 тоот захирамжуудаар нийт 25,294.0 мянга, аймгийн ЗДТГ-ын даргын 2021 оны А/119 тоот тушаалаар 47,250.0 мянга, төсөл хөтөлбөрөөр 22,268.8 мянга, бусад эх үүсвэрээр 2,434.1 мянган төгрөг үнэ төлбөргүй авсан бол төсвийн хөрөнгөөр 49,472.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Мөн аймгийн ИТХ-ын 2021 оны 44 тоот тогтоолоор 167,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 95,000.0 төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн Хөгжимт драмын

театр, ойн анги зэрэг байгууллагуудад шилжүүлсэн ба тайлант онд хөрөнгө актлаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,491,789.4 мянган төгрөг болж 298,995.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг 4,028,467.5 мянган төгрөгөөр тооцож санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс санхүүжихээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,523,941.5 мянган төгрөгөөр бууруулан 2,504,526.1 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Төсөвлөсөн зардлаас цалингийн зардлыг 378,040.3 мянга, ЭМНДШ-ийн зардал 36,104.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 186,645.2 мянга, хангамж материалын зардлыг 75,250.2 мянган төгрөг, томилолтын зардал 193,886.2 мянга, урсгал шилжүүлгийн зардлыг 126,592.2 мянга, бусад бараа үйлчилгээний зардлыг 359,514.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,140,535.3 мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 4,040,535.3 мянга, үйл ажиллагааны орлогоор 100,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 4,040,535.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 100,170.1 мянган төгрөгийн орлого оруулж, 4,127,344.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 13,360.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,127,344.8 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа бөгөөд тайлант онд ЭМНДШ-ийн зардлыг 2,782.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,782.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 2,936.2 мянган төгрөгөөр хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 676.1 сая төгрөгийн орлого орж задаргааг хүснэгтээр харуулав.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

№	Эх үүсвэр	зориулалт	Орлого /мянган төгрөг/
1	ААНБ, Иргэдээс	Тусгай зөвшөөрлийн сунгалт	778.0
2	Төсөвт байгууллага, ААНБ	Архивын лавлагааны орлого	517.5
3	Төсөвт байгууллага	Able-ийн төлбөр	3,121.0
4	Хөдөө аж ахуйн газар	Өвсний үнэ	11,964.3
5	Эмийн сангуудаас	Маскны төлбөр	19,680.0
6	ХААГазар	Буудайны үнэ	1,969.7
7	Архивын Ерөнхий газар	Архив гэрээт ажилчдын цалин	27,497.5
8	Төсөвт байгууллагуудаас	Удирдлагын Академийн Сургалтын төлбөр	3,200.0
9	ТАСЗ-өөс	ТАСЗ-ийн шалгалтын зардал	6,144.0
11	Төсөл хөтөлбөр	НҮБ хүүхэд хамгаалал, утаагүй Баянхонгор, УАЦЭА зардал	333,722.5
12	Ангилалдаагүй зардал	Хүмүүнлэгийн ордны албан хаагчдын цалин	42,125.3
13	Сангийн яам	2020 оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл	21,167.6
14	Ж.ӨЛЗИЙБАТ У-80082222	Илүү олгосон авлага	3,000.0
15	"Чандмань- Баянхонгор" ХК	Тендерийн ажил үйлчилгээний буцаалт	45,000.0
16	Аймгийн онцгой комисс	Эрдэнэмандал сургуулийн дотуур байрыг АОК-оос тусгаарлан эмчлэх байр тохижуулахад ажиллуулсан иргэд	500.0
17	Цахим Архивд	Цахим архив - Баянхонгор дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа гэрээт ажлын хөлс	30,000.0
18	Соёл урлагийн яам	Соёлын хэлтэс санхүүжилт	34,238.9
19	Техник хяналтын зардал	ХОХБТХ /2 мэргэжилтэн цалин /	1,558.2
20	БОАЖГ	Утаагүй Баянхонгор төсөл санхүүжилт	80,000.0
21	БОАЖЯам Төрийн сан	ОББҮХ 2020 оны 12 тоот гэрээний үлдэгдэл санхүүжилт	10,000.0
	Нийт дүн		676,184.6

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Аймгийн ЗДТГ нь 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 86.1%-тай дүгнүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 5,371,980.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 217,827.1 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, ЭМНДШ, тогтмол зардал, хангамж материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний үзүүлэлттэй байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас улсын төсвийн байгууллагад 120,850.0 мянган төгрөгөөр автомашин, байгууллагын урсгал зардалд багтах автомашины моторын ээлж хийх зэрэг зардлыг дэмжлэг хэлбэрээр олгож байгаа нь ТЕЗ-чийн өөрийн харьяаны байгууллагад нэн шаардлагатай бусад хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа эсэх талаар судалж үзэх нь зүйтэй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 7,722,075.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 7,675,480.2 мянган төгрөгийн 129 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 46,594.9 мянган төгрөгийн 20 мэдээг хугацаа хоцроож байршуулсан тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмжийг төсөв захирагчид өгөв. Харин 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	3	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	29	7	0
5	Тухай бүр	8	96	86	10	0
6	Нийт	27	151	129	20	2

3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 4,140,535.3 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 4,127,344.8 мянган төгрөгийг зарцуулж, 13,190.5 мянган төгрөг буюу 0.3 хувийг хэмнэсэн байна.

- Албан томилолтын зардлыг 57,739.3 мянган төгрөгөөр баталсныг бүрэн зарцуулсан байна.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 328,758.9 мянган төгрөгөөр төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 315,640.3 мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 13,118.6 мянган төгрөг буюу 4.0 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд байгууллагын батлагдсан төсөвтэй холбоотой худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10,166.9 мянган төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 96,905 мянган төгрөгийн 5 албан шаардлага өгч, 377,600.0 мянган төгрөгийн 9 зөвлөмж өгснийг аймгийн ЗДТГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 2/859 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Шийдвэрийн биелэлтээс 38385.2 мянган төгрөгийн буудайн үр албан шаардлага бүрэн биелээгүй тул аймгийн Засаг даргын 2021.11.24-ний өдрийн 1а/783 тоот албан бичгээр Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Хуулийн байгууллагад шилжүүлсэн дээрх авлагатай холбоотой нэхэмжлэлийг авч үзэх шаардлагатай.

2. Тайлант онд аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар 42,125.3 мянган төгрөгийн санхүүжилтийг ангилагдаагүй зардлаас хуваарилан хүмүүнлэгийн ордны урсгал зардал зарцуулсан ба энэхүү зардлыг цаашид менежментийн зохион байгуулалт хийж төсвөөс хөрөнгө зарцуулдаг байдлыг зогсоох шаардлагатай байна. Иймд аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн нэгтгэсэн санхүүгийн аудитаар дээрх асуудлыг зөвлөмжөөр хүргүүлэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 155,705.8 мянган төгрөгийн 6 зөрчил илэрч, 56,477.7 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 99,288.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

4.1 Албан шаардлага

1.1. Аймгийн ЭМГ-ын даргаар ажиллаж байсан В.Нарантуяаг ажлаас үндэслэлгүй чөлөөлсөнд Шүүгчийн захирамж гарч төсвөөс 12,683.7 мянган төгрөгийг гаргаж хохирлыг барагдуулсан байна

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс зарцуулсан 12,683.7 мянган төгрөгийн төсөвт учруулсан хохирлыг буцаан төлүүлэх албан шаардлагыг төсөв захирагчид хүргүүлэв.

1.2. "Их Богд" уулын тахилгад аймгийн Засаг даргын 2021 оны А/338 тоот захирамж гарч дараа тайлангаар 15,000.0 мянган төгрөг жижиг мөнгөн санд дараа тайлангаар авсан атлаа баримтын бүрдэл дутуу бүрэн тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн тахилгын үйл ажиллагаанд зарцуулсан баримтын бүрдлийг бүрэн хангаж зөрчлийг арилган биелэлтийг дахин шалгуулах албан шаардлага хүргүүлэв.

1.3. Бог малын хээлтүүлэгчийг ялган тэмдэглэх аймгийн Засаг даргын 2021 оны А/440 тоот захирамж гарч, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт дараа тайлангаар 9,294.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч тайланг ирүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бог малын хээлтүүлэгчийг ялган тэмдэглэхэд зарцуулсан зарцуулалтын ажлын тайланг холбогдох газраас авч санхүүгийн баримтад бүрдүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

1.4. Тухайн ЗДТГ нь 2021 оны 2, 6 дугаар сард 19,500.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр албан тасалгааны зориулалттай ширээ, сандал, буйдан, зэрэг тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 328,758.9 мянган төгрөгөөр төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 315,640.3 мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 13,118.6 мянган төгрөг буюу 4.0 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

Цаашид байгууллагын удирдлага Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 7,722,075.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 7,675,480.2 мянган төгрөгийн 129 мэдээллийг хугацаанд нь

байршуулж, 46,594.9 мянган төгрөгийн 20 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээг цаг хугацаанд нь байршуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	Санхүүгийн аудит										
1	ТШЗ	2	36,977.7	0	0	0	0	2	36,977.7	0	0
	Дүн	2	36,977.7	0	0	0	0	2	36,977.7	0	0
	Нийцлийн аудит										
1	ЗГ-ын 2021 оны 43-р тотоол	3	118,728.1	0	0	0	0	1	19,500.0	1	52,633.2
2	Шилэн данс	1	46,594.9	0	0	0	0	0	0	1	46,594.9
	Дүн	3	118,728.1	0	0	0	0	1	19,500.0	2	99,228.1
	НИЙТ	5	155,705.8	0	0	0	0	3	56,477.7	2	99,228.1

_____оОо_____